



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Бага тойруу, Хуульчдын талбай, Утас/Факс: (976-51) 26 26 37,
И-мэйл: turiintusgaiemneleg@gmail.com,
Вэбсайт: www.ghsss.gov.mn

2020.01.21 № 77
танай _____-ны № _____-т

Залруулга хүргүүлэх тухай

Тус эмнэлгээс цахим хэлбэрээр зарласан Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ТТАХНЭ/202012002 дугаар бүхий тендерийн баримт бичгийн Техникийн тодорхойлолтын зарим багцын эмнэлгийн хэрэгсэлд тавигдаж буй шаардлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 17 дугаар тогтоолд нийцэхгүй байгааг тодруулахыг хүссэн тендерт оролцогчийн хүсэлт үндэслэлтэй байх тул тендерийн баримт бичигт дараах залруулгыг оруулж байна. Үүнд:


1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 18.1 (б)-д заасан “санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо нь 2018, 2019 оны жилийн эцэс” гэснийг “санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо нь 2018 оны жилийн эцэс, 2019 оны эхний хагас жил” гэж өөрчлөв.

2. Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслүүдийн дэлгэрэнгүй жагсаалт, техникийн тодорхойлолтын 69 дүгээр хуудасны Багц 1 буюу Мэс заслын хэрэгслийн 10-т “суурь аппарат (генератор) дагалдуулах гэснийг; 70 дугаар хуудасны Багц 2 буюу Бөөрний мэс заслын хэрэгслийн 3-т “100 ширхэг стент гуурс тутамд 1 ширхэг стент гуурс дагалдуулах” гэснийг; мөн хуудасны 6-д “100 ширхэг шээлгүүрийн гуурс тутамд 1 ширхэг шээлгүүрийн гуурс дагалдуулах” гэснийг; 79 дүгээр хуудасны Багц 12 буюу Том үений гэмтэл, эмгэгийн мэс заслын хэрэгслийн 1-д “NAVIGATION машин хангах” гэснийг тус тус хасч залруулга хийж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Тус эмнэлгээс зарласан Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ТТАХНЭ/202012002 дугаар бүхий тендерийн баримт бичгийн ТООЗ болон Өндөр өртөг эмнэлгийн хэрэгслүүдийн дэлгэрэнгүй жагсаалт, техникийн тодорхойлолтын

холбогдох хэсэгт оруулсан дээрх залруулгын дагуу тендерийн баримт бичгээ бэлтгэж ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ,
ДЭД ХУРАНДАА



Л.БАТТӨР